Хууль сахиулахын их сургуулийн Удирдлагын сургуулийн сонсогч, хошууч Ч.Цэнгэлбаяр

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

Энэхүү өгүүлэл агуулгын хувьд хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд

Нэгд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад өнөөдөр зохион явуулж буй сургалтын бодлого, үр дүнгийн талаар

Хоёрт: Дээрхи сургалтын үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн санал бодлоо та бүхэнтэй хуваалцахыг зорьлоо.

Хорих байгууллагад зохион явуулж буй сургалтын бодлого, үр дүнгийн талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь урьдын хорих ял шийтгэлийг эдлүүлэх чиг үүрэг хүлээж байсан цаг үе өнгөрч, шүүхээс гарсан бүхий л төрлийн шийдвэрийг гүйцэтгэдэг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болон өргөжиж үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус байгууллагын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, эрүүгийн иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх онцгой бөгөөд нэн чухал ажилд 2012 оны 12 сарын байдлаар 2700 гаруй албан хаагч ажиллаж байгаагаас доктор- 0.12 хувь, магистр- 3.8 хувь, бакалавр- 36.6 хувь, дипломын дээд- 7 хувь, тусгай дунд- 12.9 хувь, бүрэн дунд- 34 хувь, бүрэн бус дунд боловсролтой- 5 хувийн боловсролтой албан хаагчид байна

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд өндөр боловсрол, мэдлэгтэй, мэргэжлийн ур чадвар сайтай, төрийн үйлчилгээний стандартыг бүрэн хангасан чадварлаг боловсон хүчинтэй байх нь тус байгууллагын "үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн байгууллага байх" гэдэг алсын хараанд нийцэж байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад дараах нийтлэг болон тусгай шаардлага тавигддаг. Нийтлэг шаардлагад:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллахыг сайн дураар хүссэн, 18 насанд хүрсэн, Монгол Улсын иргэн;

Ял шийтгэл эдэлж байгаагүй;

Офицерын албан тушаалд 35 ба түүнээс доош насны, ахлагчийн бүрэлдэхүүнд 30 хүртэлх насны иргэн;

Онцлог шаардлагатай төрөл мэргэжлийн албанд шалгаруулан авахдаа эрэгтэй 45 нас, эмэгтэй 40 наснаас дээшгүй;

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилд орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах болзол, журмын дагуу зохих сургалтанд хамрагдаж, шалгалт өгч тэнцсэн байна.

Тусгай шаардлагад:

1. Эрүүл мэнд, бие бялдрын шаардлага:

1.1. Эрүүл мэндийн байдлыг зөвхөн Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт оруулж цэргийн албанд тэнцсэн тухай дүгнэлттэй байх;

1.2. Бие бялдрын зөв хөгжилтэй, 170 см-ээс доошгүй өндөртэй

эрэгтэй, 160 см-ээс доошгүй өндөртэй эмэгтэй иргэн;

1.3. Нүүрний хэлбэр төрх болон бие эрхтэний илэрхий өөрчлөлт, гэмтэл согогтүй;

1.4. Биеийн ил гарах хэсэгт шивээсгүй, чих цоолоогүй /эрэгтэй/ байх;

1.5. Монгол улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2007 оны Е/21 дүгээр албан даалгавраар батлагдсан цэргийн албан хаагчийн бие бялдрын бэлтгэлжилтийн нормативийг хангасан байх;

2. Боловсрол, мэргэжлийн шаардлага нь:

2.1. Офицерийн албан тушаалд Цагдаагийн академи буюу бусад их дээд сургууль төгсөж бакалавр, түүнээс дээш түвшний боловсрол эзэмшсэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэргэжлийн сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан;

2.2. Ахлагчийн бүрэлдэхүүнд бүрэн дунд, түүнээс дээш түвшний боловсролтой, тухайн ажлын байрны шаардлага хангасан мэргэжил, сургалтанд хамрагдаж төгссөн;

2.3. Тасгийн дарга, түүнээс дээш албан тушаалд магистр ба эрдмийн зэрэг цолтой, удирдах ажлын мэдлэг чадвар, дадлага, туршлагатай, төрийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан;

3. Ёс зүйн хувьд тавигдах шаардлага:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилд орох иргэн нь төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж, өргөсөн тангарагтаа үнэнч байх. Үүнд:

3.1. Хүнлэг, шударга;

3.2. Зан суртахууны доголдолгүй;

3.3. Төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж явах чадвартай;

3.4. Согтууруулах ундаа болон бусад төрлийн мансуурах, донтох бодис хэрэглэх зуршилгүй;

3.5. Өөрөө болон гэр бүлийн гишүүн нь өр төлбөргүй;

3.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан байгууллага, иргэдээс шан харамж авахгүй, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;

3.7. Ар гэрийн хувьд алба хэвийн хаах боломжтой;

3.8. Улс төрийн үйл ажиллагаа явуулдаг нам болон төрийн бус байгууллагын гишүүнчлэлгүй, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа гардан хөтөлдөггүй, тэдгээрийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн бус байх зэрэг болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2009 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/65 тоот тушаалаар 2009-2019 оны хооронд Шүүхийн шийдвэр байгууллагын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг батлан үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн.

Уг сургалтын зорилгыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэргэжлийн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах, хөрвөх чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтын цогц бодлого баримтлан хэрэгжүүлэхэд оршиж байна хэмээн тодорхойлсон ба сургалтын тогтолцоо нь

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэргэжлийн албанд офицер болон бага тушаалын ахлагч бүрэлдэхүүний томилогдохын өмнөх анхан шатны сургалт:

2. Томилогдсоны дараах мэргэшүүлэх болон давтан сургах сургалт.

Сургалтын хэлбэр нь:

1. Дотоодод явуулах сургалт:
2. Бага бие бүрэлдэхүүний ахлагч бэлтгэх анхан шатны сургалт;
3. Офицерын бүрэлдэхүүнд бэлтгэх анхан шатны сургалт;
4. Бакалаврын болон магистр, докторын боловсролын зэрэг олгох сургалт;
5. Удирдах ажилтан бэлтгэх, давтан сургах сургалт;
6. Мэргэжил олгох болон мэргэжил дээшлүүлэх, давтан сургах сургалт.,
7. Гадаад хэлний мэдлэг олгох сургалт;
8. Олон улсын энхийг сахиулах хүчинд алба хаах цэргийн албан хаагчдыг бэлтгэх сургалт гэсэн хэлбэртэй байна.

Дээр дурдсанчлан нийтлэг болон тусгай шаардлага хангасан ажилтан, албан хаагчдыг бэлтгэх, сургаж, давтан сургах, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр өнөөгийн байдлаар дор дурдсан бодлого, төлөвлөлтийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад томилогдохын өмнөх сургалтанд Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажилд орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах болзол, журам"-д заасан шаардлагыг хангасан иргэдээс мэргэшлийн шалгалтыг сонгон шалгаруулалт хэлбэрээр авч анхан шатны сургалтыг зохион байгуулж явуулж ирсэн. Сургалтанд хууль эрх зүйн анхан шатны болон цэргийн хэргийн, бие бялдрын мэдлэг олгох чиглэлээр бакалаврын болон түүнээс дээш боловсролтой иргэдэд 50 цаг, ахлагчийн бүрэлдэхүүнд орж ажиллахыг хүссэн бүрэн дунд боловсролтой иргэдэд 70 цагийн хичээл сургалтыг 14 хоногийн хугацаатайгаар зохион явуулахаар хичээлийн цаг сэдвийн хөтөлбөрийг боловсруулан ШШГЕГ-ын даргын тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна.

2. Өнгөрсөн 2012 онд тус байгууллагад ажилд шинээр орох иргэдийн томилогдохын өмнөх сургалтыг хууль, эрх зүйн тойм болон байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, цэргийн дүрэм, албаны бэлтгэл гэсэн чиглэлээр батлагдсан хөтөлбөрийн дагуу 4 удаа зохион байгуулж, дээрхи сургалтанд нийт 719 иргэн хамрагдсанаас, сургалтанд хамрагдсан иргэдээс эрх зүйн болон цэргийн анхан шатны мэдлэг, бие бялдрын түвшин, ярилцлагын хэлбэрээр шалгалт авснаас 310 иргэн тэнцэж, ШШГЕГ-ын даргын тушаалаар төв, орон нутаг дахь хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадад зохих албан тушаалд томилогдон ажилласан байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар нийт хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадын хэмжээнд хууль эрх зүй, цэргийн хэргийн мэдлэг, бие бялдар, харилцах урлаг, компьютер, албан хэрэг хөтлөлт зэрэг багц сэдвийн хүрээнд ажиллаж буй нийт ажилтан, албан хаагчдад жил бүрийн 12 дугаар сарын 15-наас дараа оны 5 дугаар сарын 1-ний хооронд албаны сургалтыг зохион байгуулж явуулдаг. Сургалтыг ерөнхий газрын даргын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу хорих анги, шийдвэр гүйцэтгэх албад өөрсдийн онцлогт тохируулан сургалтыг явуулж ирсэн.

4. Албаны хэмжээнд дээрхи сургалтыг явуулахаас гадна ХСИС-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажил-эрх зүй мэргэжлээр өдөр, эчнээ ангид, бусад

иргэний сургуулиудад эмч, эдийн засагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэргээр нарийн мэргэжлээр суралцуулан ажлын байраар хангаж байна.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадад ажиллаж буй албан хаагчдын дунд төрөл мэргэжлээр давтан сургалт зохион байгуулан ажилладаг тухайлбал: төлөөлөгч, ээлжийн дарга, нийгмийн ажилтан, шийдвэр гүйцэтгэгч, харуул хамгаалалтын бие бүрэлдэхүүний зэргээр тодорхой сургалтыг бүсчилсэн болон төвлөрсөн хэлбэрээр зохион байгуулан мэргэжил мэдлэгийг нь дээшлүүлэн ажиллаж ирсэн байна.

6. Мөн тус байгууллагын зүгээс гадаад хамтын ажиллагааны хүрээнд мэргэшүүлэх болон туршлага солилцох сургалтыг Оросын Холбооны Улс болон бусад улсуудад албан хаагчдаа сургаж бэлтгэж байна.

Хорих байгууллагын алба хаагчдын сургалтын үр дүнг дээшлүүлэх нь

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын боловсон хүчнийг сургаж бэлтгэх, давтан сургах ажиллагаанд ХСИС ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж ирсэн ба өнөөдөр ч гүйцэтгэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сургалтын стратеги хөтөлбөрт тус байгууллагын сургалтын талаархи хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохдоо:

а/ Сургалтын хэрэгцээг байгууллагын удирдлага болон албан хаагч хамтран тодорхойлж хэрэгжүүлдэг болно.

б/ үйл ажиллагааны чадавхи сайтай анги, алба байгууллага бий болно.

в/ Хэрэгцээтэй мэдлэг боловсрол, мэргэжлийн өндөр ур чадвар бүхий албан хаагчдаар хангагдсан байна.

г/ Төрийн албан хаагчдын байнга сурч боловсрох боломж нэмэгдэж тэдний манлайлал, үйл ажиллагааны оролцооны түвшин нэмэгдэнэ гэж тодорхойлсон.

Хэдийгээр дээр дурьдсанчилан албан хаагчдыг томилогдохын өмнөхөөс эхлэн төрөл мэргэжил, албан тушаал бүр дээр мэргэшүүлэх, давтан сургалт гэх мэт олон хэлбэр төрлийн сургалтыг явуулж байгаа боловч дараах дутагдалтай тал байна. Үүнд:

1. Томилогдохоос өмнөх сургалтанд: сургалтын хугацаа 14 хоног байдгаас суралцагч нар нь байгууллагын үйл ажиллагаа, онцлог, мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн актыг бүрэн мэддэггүй төгсч, алдаа дутгадал гаргах, айж шантрах зэрэг байдлаас болж ажил албаа орхих нь их байдаг.

2. Хорих анги, албанд явагдах сургалт нь: хэдийгээр ШШГЕГ-ын даргын баталсан цаг сэдвийн хүрээнд хичээл сургалтыг тухайн хорих анги албанд ажиллаж байгаа тодорхой албан тушаалтангууд, шинээр төгсөж офицерууд, олон жил ажиллаж байгаа туршлага бүхий албан офицерууд заадаг. Энэ тухайн албан хаагчийн мэдлэг, бусдад хичээл заах чадвар, албан хаагч нарын хүлээж авах хандлага зэргээс шалтгаалан үр дүн муу байдаг.

3. Мэргэшүүлэх болон давтан сургалтанд: Хэдийгээр тухайн төрөл мэргэжлийн багш нарыг гаднаас урьж, хөрөнгө мөнгө зарж, мэргэшүүлэх болон давтан сургалтыг тухайн мэргэжлийн нийт албан хаагчдад ордог боловч мөн л байгууллагын онцлог, төрөл дэглэмийн ялгаанаас болж сургалт үр дүнгүй, хөрөнгө зарсан сургалт болох дутагдал байдаг.

4. Бакалаврын боловсролын зэрэг олгох сургалтанд; сурч байх хугацаанд хорих анги албанд хийх дадлагын ажлыг биечлэн хийдэггүй, хугацаа бага, төгсөгчдийн онолын болон практик үйл ажиллагааг гардан гүйцэтгэх чадвар төдийлөн шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Иймд сургалтын үйл ажиллагааг сайжруулах, албан хаагчдын мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Томилогдохоос өмнөх сургалтын 14 хоногийн хугацааг 6 сарын хугацаатай болгож **онол-практик-онол** хосолсон сургалт болгон зохион байгуулж чанарыг сайжруулах.

Хорих байгууллагын албан хаагчдын төрөл мэргэжлийн давтан сургалтын чанарыг сайжруулах, сургалтыг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хэлбэрээр зохион байгуулах, албан хаагчдын сургалтын үйл ажиллагаанд бусад хууль хяналтын болон их, дээд сургуулийн эрдэмтэд, багш нарыг өргөнөөр татан оруулах чиглэлээр томоохон ажлыг шат дараалалтайгаар хийх хэрэгтэй байна.

Хорих байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, олон улсын стандарт жишигт хүргэх зорилго тавин ажиллаж буй өнөө үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын сургах үйлсд гадаад сургалтыг өргөнөөр ашиглах хэрэгтэй бөгөөд боловсон хүчний томилгоо, тогтвор суурьшил, нийгмийн баталгаанд анхаарч ажиллах.

Гадаад орнуудын хорих байгууллагын эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны талаарх өргөн мэдээллийг тухайн оронд нь очиж судалхаас гадна эрдэмтэн багш, судлаач нар дээрхи асуудлыг судалгаа шинжилгээний ажлынхаа хүрээнд судлан ном гарын авлагадаа тусгаж нийтийн хүртээл болгох нь чухал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон тогтоол гүйцэтгэх ажиллагаанд хамааралтай тодорхой ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэхэд онцгой анхаарч ажиллах шаардлагтай.

Цаашид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, ХСИС-ын хамтын ажиллагааны талаарх зөв оновчтой хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зүйтэй гэж үзэж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.